Хэдийгээр хүмүүс бусадтай мөн бусадад амидардаг ч гэлээ бид бүгдээрээ л ганцаараа. Тиймээс төрөхөөсөө авахуулаад үхэх хүртэл өөрийнхөө л замаар явж, ертөнцийг туулдаг. Өөрийнхөө өвчинийг хүн зөвхөн өөрөө л мэдэрдэг. Хүн бусадын өвчинийг мэдрэх боломжгүй. Бусад бас миний өвчинийг мэдрэх чадваргүй. Хүн бүр үхэл рүү ганцаараа л явдаг. Хэрэв хүн хаа нэг тийшээ явлаа гэхэд бусад түүнийг заавал дагахгүй. Мэдээж өрөөн дотор хэсэг хүмүүс байлаа гэхэд тэднийг бие даасан хүн гэдэгээр тоолох бол мэдээжийн хэрэг. Гэтэл зарим нийгэмд буюу ард түмэнүүдэд бие хүн гэсэн ганцаарчилсан ойлголт байдаггүй. Плато “Хуулиуд” гэсэн номондоо али болох л хамтаараа тухай өгүүлсэн. Жишээлбэл: Хамтаараа харах гэвэл бүгд л адилханаар харах, хамтаараа сонсох гэвэл бүгд л адилхан сонсох, хөдөлмөрлөх гэвэл мөн хамтаараа хөдөлмөрлөх гэх мэт хамтын болон хамтарсан мэдрэмжийн тухай бичжээ. Өнөөдөр иймэрхүү ард түмэнүүдийн жишээ үгүй.

Эрчимтэйгээр бусадаас тусдаа

Хүн бүр хэн хэнээсээ тусгаар тул хүн бүрийн амидрал өөрийн гэсэн орон зайг мөн өөрийн гэсэн ахуй орчинд явагдана. Эд зүйл, гэр орон, нутаг ус гэх мэтийг хүн хайж түүндээ амидарч тэгсэнээрээ тэдгээр тухайн хүний түүх болж мөн найз нөхөд үүсэж, цаашилбал сэксийн харицаа тогтоно. Энэ бүх шинжүүд бусадыхаас ялгаатай ганцхан тул түүгээрээ хүн хэн бэ гэдэгээ таниулна. Хэдийгээр нийгэмүүд хүмүүсийн хэр эрчтэй тусгаарлалтыг зөвшөөрдөг мөн дэмждэг байдалаараа ялгаатай ч хэн ч бүрэн хорионд амидрахгүй. Тэр ч бүү хэл минийх ба минийх биш гэсэн ягштал салгасан амидрал боломжгүй. Хүн би хэрхэн шүргэж, хэрхэн хэрэглэж, хэрхэн дурлаж буйгаагаараа мөн бусадын намайг хэрхэн шүргэж, хэрхэн хэрэглэж, хэрхэн дурлаж буйг мэдэрч буйгаагаараа хүн би зөвхөн өөрийнхөө өнцгөөс л дүгнэдэг. Хүн минийх гэж нэрлэж буй бусадын минийх гэдэгтэй яг адилхан биш. Үнэндээ бол бид хүн бүр өөрийнхөө оронд өөрийнхөө хүсэлээр хөдөлж, хүсэж буй зүйлээ эзэмшиж, хэрэглэх гэсэн зүйлээ хэрэглэж, хадгалах гэсэн зүйлээ хадгалаж, хайрлах гэсэн зүйлээ хайрлах тэр л боломжтой орон зайг хүсэж мөрөөддөг гэдэгийг хүлээн зөвшөөрөх ёстой.

Дээрх нэрлэсэн хуви хүний хүсэл шаардлагыг гэх мэтээр үргэлжилүүлэн жагсааж өргөтгөх шаардлагатай. Тиймээс энэ жагсаалт нээлттэй. Магадгүй тухайн хүн заримыг хасна бас шинээр хүсэлт нэмнэ. Тэгсэн хэдий ч хүн ямар амидралыг сайн амидрал вэ? гэдэг эргэлзээтэй.

Дээрх жагсаалт ажиглахад үнэлгээний характэртэй. Яагаад гэвэл тухайн хүн заримыг үнэлнэ, заримыг үнлэхгүй. Хүний амидралд юу хэрэгцээтэй вэ, юу хэрэгцээгүй вэ гэдэгээр тэр амидралыг амидрал мөн эсвэл биш гэнэ. Тиймээс дээрх жагсаалтын хуудас хоёр зүйлийг тусгах ёстой: хязгаар ба чадвар. Хэрэв чадварын тухай ярина гэвэл нилээд гүн үнэлгээ хэрэгтэй. Тиймээс хүмүүст хэрэгтэй чадварууд үгүй гэвэл нилээд дутагдалтай бас ядуу амидрал тул түүнийг сайн амидрал гэж хэлэхгүй. Хязгаартай гэдэг нилээд төвөгтэй асуудал. Яагаад гэвэл хүмүүс амидралдаа тэр л хязгааруудын эсрэг тэмцдэг. Хүмүүс өлсөхийг хүсэхгүй, өвдөж зовохыг хүсэхгүй мөн үхэхийг хүсэхгүй. Ер бол хүн тусадаа маш комплэкс асуудал бөгөөд тэнд хязгаар болон чадварын тухай л яридаг. Мэдээж хүн тэр хязгааруудаас бүрэн чөлөөлөгдөхгүй. Хүний амидралын шинж төрх дахин дахин цангадаг, дахин дахин өлсдөг тул идэж уухаас чөлөөлөгдөхгүй. Үүнтэй адил хүн сэксээр дутагдаж түүнийгээ хангах шаардлагатай. Тийм учираас дутагдал болон хангалт хоёроос чөлөөлөгдөх боломжгүй. Эцэсийн эцэст үхэлийн тухай хүн сайн бодох бол түүнээс тэр бүр чөлөөлөгдөхийг хүсэхгүй. Хэрэв хүн үхэхийг хүсэхгүй гэвэл цаашид шал ондоо төрөлийн амидралд орж мөн үүнтэй ижил ондоо төрөлийн үнэлгээнүүд үйлчлэх амидрал руу орно гэсэн үг бөгөөд тэр ч бүү хэл тухайн хүн өөрөө цаашид хэвээрээ оршино гэдэгт итгэх боломжгүй. Тиймээс хүний амидралын хязгаарын тухай чухал асуултуудыг үнэлж дүгнэх тийм ч амар биш.

Бидний энд яриж буй хоёр дахи шинж болох хүний чадваруудыг али тэгээд амидралд хэрэгтэй чадвар гэдэгээр ангилах ёстой. Ингэж жагсаасан хуудсанд хоорондоо хамааралтай чадваруудыг тусгах, түүнээс биш хийх чадвар буюу хий гэсэнийг хийдэг чадвар биш ээ.

Хүний суури чадварууд

Нэгдүгээр чадвар: Энэ чадвар хүн амидралаа бүтэнээр төгсгөл хүртэл авч явах чадвар. Хугацаанаасаа өмнө үхэхгүй. Өөрөөр хэлбэл амидрал ямар ч үнэгүй болоогүй цагт үхэхгүй шүү гэсэн чадвар.

Хоёрдугаар чадвар: Эрүүл яваадаа баярлах чадвар. Тиймээс тохируулан хооллох, тухтай орон байр, боломжоороо сэксийн шаардлагаа хангах мөн хаа нэг газар нүүн очих чадах чадварууд хамаарна.

Гуравдугаар чадвар: Хэрэгцээгүй өвдөлтүүдийг зайлуулах чадвар мөн баяртай мөчүүдийг эдлэх чадвар.

Дөрөвдүгээр чадвар: Таван мэдрэлийн эрхтэнүүдээ хэрэглэх чадвар. Төсөөлөх чадвар, бодох чадвар, ялгаварлах чадвар.

Тавдугаар чадвар: Өөрөөсөө бусадтай холбоо тогтоох чадвар, мөн бусад зүйлд хандсан холбоо тогтоох чадвар. Өөрийгөө хайрласан болон халамжилсан хүнийг буцаагаад хайрлаж мөн халамжилж чадах чадвар. Тэр хүмүүсийнхээ үгүйд эмгэнэл илэрхийлэх чадвар. Өөрөөр хэлбэл бусадыг хайрлах болон бусадад гашуудах чадвар. Тэмүүлэх болон талархах зэрэгийг мэдрэх чадвар.

Зургаадугаар чадвар: Сайны тухай төсөөлөх чадвар. Мөн өөрийнхөө амидралын төлөвлөгөөнд шүүмжтэйгээр бодох чадвар.

Долоодугаар чадвар: Бусадад зориулан амидрах чадвар. Бусад хүмүүстэй холбоотой гэдэгээ танин мэдэх чадвар. Мөн янз бүрийн хамаатан саданы болон социалын харицааны хэлбэрүүдэд оролцох чадвар.

Наймдугаар чадвар: Бусад амитан ургамал болон байгалтай холбоотойгоор амидрах чадвар. Мөн тэдгээрт халамжтайгаар хандах чадвар.

Есдүгээр чадвар: Инээх болон тоглох чадвар. Амралтын мөчүүдэд баярлах чадвар.

Аравдугаар чадвар: Өөрийнхөө амидралаараа амидрах харин бусадын амидралаар амидрахгүй чадвар.

Арваннэгдүгээр чадвар: Өөрийнхөө сонгосон орчиндоо болон өөрийнхөө тодорхойлсон хувийн амидралаар амидрах чадвар.

Энд жагсаасан чадваруудын тухай жагсаалт хүний амидралд чухал үүрэгтэй. Хэрэв дээрх чадваруудын али нэг хэн нэг хүнд дутагдлаа гэвэл тухай хүнийг хүний

амидралаар амидарч байна гэхэд эргэлзээтэй. Тиймээс дээрхүүдийг амидралынхаа гол асуудалаа болгох ухамсартай хэрэг бөгөөд мөн төр засаг ч гэсэн дээрхүүд хүний амидралын сайнууд гэдэгээр дэмжих ёстой. Дээрх жагсаалт сайны тухай минимал теори. Энд юуг тодорзуулан хэлэх вэ гэхээр дээрх чадварууд хоорондоо холбоогүй биш тиймээс нэг нэгэнээсээ хамааралтай. Мөн заримууд нэг нэгэндээ нөлөөлдөг. Жишээлбэл: Хамааралтай байна гэдэг хөдөлгөөн болон хооллох хоёрын харицаа. Аристотэлийн хэлсэнээр энэ хоёрын харицаа хүнс бол хөдлөхөд чухал үүрэгтэй гэсэн харицаа. Тиймээс энэ хоёр бие биенээсээ хамааралтай. Ондоо нэг хамааралын тухай жишээ бол хүний тусгаар байдал. Хүн заавал орон, хугацаанд тусгаа. Мэдээж ан амитан, мод ургамалд халамжтайгаар хандах ёстой гэсэн чадвар хүний хоол хүнс, эрүүл мэнд гэсэн чадваруудтай харшилдаг. Тиймээс дээрх жагсаалтанд заасан чадваруудыг хооронд харицуулан мөн зөрчилүүдийг ойлгох хэрэгтэй. Тиймээс сайнуудыг хэрхэн олон гэдэгийг мөн тэдгээр хоорондоо юугаараа ялгаатай гэдэг чанарын ялгаануудыг танин мэдэх ёстой. Тиймээс жагсаалтанд заасан чадваруудыг политикийн хувид болон этикийн хувид авч үзэхэд эртний грэкийн политэйзмийг санагдуулдаг. Тиймээс хүний янз бүрийн байдлаас шалтгаалан олон төрөлийн бурхадууд байдаг. Үүнтэй ижил хүний амидралын хэлбэр төрх олон янз. Зарим хүмүүсийн сонирхолыг төрүүлнэ. Мөн зарим хүний хүндэтгэлийг төрүүлнэ. Ингэж хүний амидралыг хэрхэн чанартай вэ гэдэгийг дээрх олон талын цэгүүдээс үнлэх шаардлагатай. Тэглээ ч гэсэн бурхад үргэлж бидний талд байж чадахгүй. Тиймээс бидний зарим хүсэл шаардлагууд бусадынхтай заавал эвлэрэх өөрөөр хэлбэл хармонилох боломж үгүй.

Үргэлжилэл бий...

А. Аайнз

(brothers_3399@yahoo.com)


**Хүн ямар вэ түүний бурхан яг тийм. Ийм болохоор
тэд үргэлж бусдын хошигнол болдог.**

Гээтэ.



Карл Маркс

(Karl Marx)



“Капитал”

буюу

политикчилсон экономын критик

Нэгдүгээр дэвтэр: Капиталын бүтээгдэхүүний процесс

Хэсэг 1: Бараа ба мөнгө

Бүлэг 1: Бараа

2. Барааны дотор дүрслэгдсэн хөдөлмөрийн давхар характэр

Бараа анхнаасаа бидэнд хоёрдмол туссан ба нэгд, хэрэгцээний үнэт, хоёрт, солилцооны үнэт. Сүүлд хөдөлмөр ч гэсэн үнэт дотор гэдэгээр илэрхийлэгдэхдээ солилцооны үнэтийн үйлдвэрлэгч гэсэн шинжээ алдсан. Бараан дотор агуулагдсан хөдөлмөрийн энэ хоёр салаа натурын тухай би критиклэсэн. Яагаад гэвэл политикчилсон экономыг ойлгоход гол асуудалын цэг бөгөөд тиймээс үүнийг энд ойртуулан гэрэлтүүлцгээе.

Үүний тулд хоёр барааг сонголоо. Нэгд, бошинз, хоёрт, арван эллэтэй³⁵ зурагийн цаас.³⁶ Эхнийх дараагийнхаасаа хоёр дахин үнэттэй. Тиймээс арван эллэ зурагийн цаас = 1ү (үнэт), бошинз = 2ү.

Бошинз солилцооны үнэттэй ба яагаад гэвэл тэр онцгой шаардлагыг хангадаг. Түүнийг гаргахын тулд продуктив ажилын тодорхой төрөл хэрэгтэй. Үүнд: зорилго, хийх төрөл, тухайн зүйл, багаж болон дүн. Тодорхой хөдөлмөрийн ашиг

³⁵ Зурагийн цаасны хэмжээ;

³⁶ Зурагийн цаасанд тухайн үед нэхмэлийг аргыг хэрэглэжээ;

түүний продуктын солилцох үнэт дотор дүрслэгдвэл мөн энэ продукт солигдох үнэттэй гэвэл түүнийг товчоор ашигтай хөдөлмөр гэж нэрлэнэ. Ингэж түүний ашигийн эффэкттэй хамааруулан ажигладаг.

Бошинз ба зурагийн цаас квалитигаараа янз янзын солилцох үнэтүүдтэй. Тиймээс тэдгээрийн Дазайн-аар дамжуулсан хөдөлмөрүүд квалитигаараа бас янз янзын. Жишээлбэл эсгүүр би нэхмэл. Хэрвээ юмс янз янзын квалититэй солилцооны үнэтгүй, мөн продуктууд квалитэтээр янз янзын ашигтай хөдөлмөрүүдээс гэвэл тэднийг бараанууд гэх боломжгүй. Бошинзыг бошинзоор солихгүй. Яагаад гэвэл адилхан солилцооны үнэтийг мөн адил солилцооны үнэтээр солихгүй.

Янз янзын төрөлийн солилцооны үнэтүүдийн буюу барааны нийлмэл дотор үүнтэй адил олон төрөлийн гаралтай, шинжтэй, фамилитай, доод төрөлтэй, мөн гажуу төрөлийн гэх мэт янз янзын хөдөлмөрүүдийн нийлмэл тусдаг ба ингэж хөдөлмөрийн нийгэмчилсэн хэсэгүүд үүснэ. Тэдгээр барааны продуктын эксистэнц болзол. Харин барааны продукт урвуугаар нийгэмийн хөдөлмөрийн хуваалтуудын эксистэнц болзол биш. Эртний Энэтхэгийн тосгонд хөдөлмөрийг нийгэмчилэн хуваахдаа продуктуудыг бараа болгуулахгүйгээр хуваажээ. Ондоо ойролцоо жишээгээр фабрик бүрт хөдөлмөрийг систэмтэйгээр хуваасан. Гэхдээ энэ хуваалт юугаар дамжаагүй вэ гэхээр хөдөлмөрчид өөрсдийн индивидуал продуктуудаа солилцоогүй. Зөвхөн бие дааж мөн бусадаас хамааралгүйгээр приват хөдөлмөрөөс гарсан продуктуудыг бараанууд гэсэн. Энд юу харагдсан бэ гэхээр бараа бүрийн хэрэгцээний үнэт дотор нэгд, тодорхой зорилготой продуктив ажил, эсвэл ашигтай хөдөлмөр орсон. Хэрвээ солилцооны үнэт дотор квалитэтээр янз янзын ашигтай хөдөлмөрүүд ороогүй гэвэл тэдгээр бараа болохгүй. Продуктууд ерөнхийдөө барааны формыг авдаг нийгэмд нэг үгээр хэлэхэд барааны продуцентуудын нийгэм дотор дээрх ашигтай хөдөлмөрүүдийн квалитигийн ялгаа хөгждөг. Ингэхдээ бие даасан продуцентуудын хоорондоо хамааралгүй приват бизнэс гэдэгээр явагдах ба ингэж олон гишүүдтэй систэм ондоогоор хөдөлмөрийн нийгэмчилсэн хуваалт болдог.

Бошинзны хувид эсгүүрчин үү эсвэл эсгүүрчиний үйлчлүүлэгч түүнийг өмссөн үү гэдэг ялгаагүй. Энэ хоёрт хоёуланд бошинз солилцох үнэт гэдэгээр үйлчилнэ. Үүнтэй адил бошинз ба түүнийг продукталсан хөдөлмөр хоёрын хоорондын харилцаа эсгүүрчин онцгой мэргэжил үү, мөн хөдөлмөрийн нийгэмчилсэн хуваалтын бие даасан гишүүн үү гэдэг өөрчлөлт өгөхгүй. Хүн эсгүүрчин болохоос өмнө хүмүүс хувцас шаардлагатай л гэвэл мянга мянган жил эсгүүрдэж ирсэн. Гэхдээ бошинзны, мөн зурагийн цаасны Дазайн нэг үгээр хэлэхэд натураас биш эдүүдийн баялагийн элэмэнтүүдийн Дазайн юугаар дамжуулан үргэлж илэрхийлэгддэг вэ гэхээр спициэл бас зорилготой ажилаар бөгөөд онцгой натурын эдүүд хүмүүсийн онцгой шаардлагуудад тохируулагдсан. Солилцох үнэтүүдийг гаргасан гэдэгээрээ мөн ашигтай хөдөлмөр гэдэгээрээ хөдөлмөр тэгэхээр бүхий л

нийгэмийн формуудаас хүний хамааралгүй эксистэнц болзол. Мөн мөнхийн натурын зайлшгүй ба энэ хөдөлмөр хүн ба натурын эдийн солилцоо ба тэгэхээр хүний амидралыг дамжуулах хөдөлмөр.

Бошинзны болон зурагийн цаасны солилцооны үнэтүүд, нэг үгээр хэлэхэд барааны биетүүд натурын эд ба хөдөлмөр гэсэн хоёр элэментүүдийн холбоос. Хэрвээ бошинзонд болон зурагийн цаасанд орсон янз янзын ашигтай хөдөлмөрүүдийн нийт нийлбэрийг хасвал зөвхөн матэриаллаг субстрат үлдэх ба нэг үгээр хэлэхэд хүний ямар ч үйлдэлгүйгээр натураасаа өгөгдсөн гэнэ. Хүн продукт дотороо зөвхөн явагдах ба яг л натуртай адил. Нэг үгээр хэлэхэд эдүүдийн зөвхөн формууд өөрчлөгдөнө. Энэ формуудынхаа хөдөлмөр дотор хүн үргэлжийн натурын хүчнүүдээр дэмжүүлдэг. Тэгэхээр хөдөлмөр түүгээр продуктлагдсан солилцооны үнэтүүдийн буюу эдүүдийн баялагийн цорын ганц булаг биш. Тиймээс Виллиам Пэттигийн³⁷ хэлсэнээр хөдөлмөр түүний эцэг газар түүний ээж.

Ингээд бараанаас нэг үгээр хэлэхэд солилцооны зүйлээр дамжуулан барааны үнэт рүү очицгооё.

Бидний ажигласнаар бошинз зурагийн цааснаас хоёр дахин үнэттэй. Бидэнд энэ зөвхөн квантитатив ялгаа тул эхлээд бидэнд сонирхолгүй. Бид арван эллэ зурагийн цааснаас бошинзыг хоёр дахин үнэттэй гэсэн ба мөн хорин эллэ зурагийн цаас бас л үүнтэй ижил үнэттэй бошинзтой тэнцэнэ. Үнэтүүд гэдэгээрээ бошинз ба зурагийн цаас адилхан субстанцтай юмнууд ба адилхан төрөлийн хөдөлмөрийн обэктив илэрхийлэлүүд. Гэхдээ эсгүүр ба нэхмэл квалитатив янз янзын хөдөлмөрүүд. Гэтэл зарим нийгэмийн төлөвүүдэд хүн эсгүүрдэнэ бас нэхнэ. Энэ хоёр янзын хөдөлмөрийн шинжүүд зөвхөн тухайн индивидуумын хөдөлмөрийн хувиралууд. Яг л эсгүүрчин өнөөдөр бошинз эсгүүрдэнэ харин маргааш өмд эсгүүрдэнэ. Ингэснээрээ тухайн индивидуал хөдөлмөрийн хоёр өөрчлөгдсөн формуудыг уридчилдаг. Тиймээс капиталист нийгэмд хөдөлмөрийн эрэлт хэрэгцээний солбицсон чиглэлээр хүмүүсийн хөдөлмөрийн өгөгдсөн порцууд эсгүүрийн цормоор эсвэл нэхмэлчийн формоор солбицон явагдана. Иймэрхүү хөдөлмөрийн формын солбицолууд тийм ч зөрчилгүй биш, гэхдээ л явагдах ёстой. Хэрвээ хүн тэдгээрийн продуктив ажилын тодорхойнуудыг, мөн хөдөлмөрийн ашигтай характэрийг харвал дээрх хүний хөдөлмөрийн хүчний гарцууд. Хэдийгээр эсгүүрчин ба нэхмэлчин квалитигээр янз янзын продуктив ажилууд ч гэсэн хоёулаа хүний тархины, булчингийн, нэрвийн, гарын гэх мэт продуктив гарцууд. Тиймээс дээрх хоёр хоёулаа хүний хөдөлмөр. Тэр хоёр зөвхөн хүний хөдөлмөрийн хүчийг гаргадаг янз янзын формууд. Чухамдаа хүний хөдөлмөрийн хүч али ч формоор гаргаж чадахын тулд их бага ч хөгжих шаардлагатай. Барааны үнэт хүний хөдөлмөрийг нэг үгээр хэлэхэд хүний хөдөлмөрийн гарцыг дүрсэлдэг. Иргэнчилсэн

³⁷ Английн экономич;

нийгэм дотор цэрэгийн гэнэрал эсвэл банкны эзэн том дүрүүдийг тоглодог ба харин хүн доогуур дүрийг тоглодог. Яг л үүнтэй ижил хүний хөдөлмөр дүрслэгдэнэ. Энэ энгийн хөдөлмөрийн хүчний гарц ба дундажаар ямар ч энгийн хүн мөн ямар ч онцгой хөгжилгүйгээр, нэг үгээр хэлэхэд биеийнхээ организм дотор онцгой хөгжилгүйгээр гаргах гарц. Энгийн дундаж хөдөлмөр тухайн улсад эсвэл тухайн културын эринүүдэд өөрийнхөө характэрийг солидог ба бэхэжсэн нийгэмд өөрөө өгөгдсөн. Төвөгтэй хөдөлмөрүүд потэнцтой, эсвэл илүү олонлогжсон энгийн хөдөлмөр ба тиймээс төвөгтэй хөдөлмөрийн жижигхэн квант энгийн хөдөлмөрийн том кванттай тэнцүү. Ингэж рэдукцлэх үргэлжийн гэдэгийг туршлага харуулдаг. Тухайн бараа төвөгтэй хөдөлмөрийн продукт гэвэл түүний үнэт энгийн хөдөлмөрүүдийн продукттай тэнцэх ба тэгсэнээрээ энгийн хөдөлмөрийн тодорхой квантыг зөвхөн дүрсэлдэг. Янз янзын пропорцууд дотор янз янзын хөдөлмөрийн төрөлүүд энгийн ажил гэдэгээрээ түүний хэмжих нэгж гэж рэдукцлэгдвэл нийгэмийн процессоор продуцэнтийн араар дээрх нэгжийг тогтоочихсон ба тиймээс тэдэнд угаасаа өгөгдсөн мэт. Хялбарчилахын тулд цаашид хөдөлмөрийн хүчний төрөл бүрийг шууд энгийн ажилын хүч гэх ба ингэснээр тэдгээрийг рэдукцлэх шаардлагагүй.

Бошинзны болон зурагийн цаасны үнэтүүд дотор тэдний солилцооны үнэтүүдийн ялгаа абстракцлагдсантай адилаар энэ үнэтүүд дотор дүрслэгдсэн хөдөлмөрүүд дотор тэдгээрийн ашигийн формуудын ялгаа нэг үгээр хэлэхэд эсгүүрийн ба нэхмэлийн ялгаа абстракцлагдсан. Бошинзны болон зурагийн цаасны солилцооны үнэтүүд алчуураар болон утасаар продуктиваар зорилготой ажилласны холбоосууд гэдэгтэй адилхан бошинзны болон зурагийн цаасны үнэтүүд зөвхөн нэг төрөлийн хөдөлмөрийн галлэртууд гэдэгтэй адилхан тэдгээр үнэтүүд дотор орсон хөдөлмөрүүд алчуурын болон утас руу хэрхэн продуктив гэдэгээрээ хүчинтэй биш, харин хүний хөдөлмөрийн хүчний гарцууд гэдэгээрээ зөвхөн хүчинтэй. Бошинз болог зурагийн цаасны солилцооны үнэтүүдийн боловсруулсан элэмэнтүүд эсгүүр ба нэхмэл өөрсдийн янз янзын квалитэттэй. Бошинзны үнэтийн болон зурагийн цаасны үнэтийн субстанц зөвхөн хэдийд вэ гэхээр тэдгээрийн онцгой квалитиг абстракцалсан үед ба мөн адилхан квалитэт эзэмшсэн үед. Нэг үгээр хэлэхэд хүний хөдөлмөрийн квалити.

Бошинз ба зурагийн цаас зөвхөн үнэтүүд биш, мөн тодорхой хэмжээнүүдийн үнэтүүд. Бидний тооцоолсоноор бошинз 10 тохой зурагийн цааснаас хоёр дахин илүү үнэттэй. Тэгэхээр хаанаас тэдний үнэтүүдийн хэмжээний ялгаа гаралтай вэ? Хаанаас гаралтай вэ гэхээр зурагийн цаас бошинз хийснээс хоёр дахин бага хөдөлмөр агуулдаг. Тиймээс бошинзыг үйлдвэрлэхэд зарцуулсан хөдөлмөрийн хүч зурагийн цаас үйлдвэрлэхээс хочр дахин илүү хугацаа зарцуулсан.

Хэрвээ бараан дотор агуулагдсан хөдөлмөр хэрэглээний үнэтэд харицуулсанаар квалитатив хүчинтэй гэвэл үнэтийн хэмжээнд харицуулсанаар квантитав хүчинтэй.

Энэ цаашидын квалитэтгүйгээр али хэдийн хүний хөдөлмөрт редуцлэгдсэн. Тэнд хөдөлмөрийн яаж бас юу гэсэн тухай ярих ба харин энд түүний хэдий их мөн хугацааны тухай ярина. Яагаад гэвэл барааны үнэтийн хэмжээ түүнд агуулагдсан хөдөлмөрийн квантыг дүрсэлдэг тул бараанууд тодорхой пропорцоор үргэлж адилхан хэмжээний үнэтүүдтэй.

Хэрвээ бүтээгдэхүүний хүч буюу нэг үгээр хэлэхэд бошинзыг үйлдвэрлэхэд гаргасан ашигтай хөдөлмөр өөрчилөгдөхгүй гэвэл бошинзны үнэтийн хэмжээ өөрийнхөө квантитэтээр өснө. Хэрвээ нэг бошинз нэг ажилын өдөрийг дүрсэлвэл хоёр ажилын өдөрийг дүрсэлнэ гэх мэт. Тэгвэл бошинзыг үйлдвэрлэхэд зайлшгүй хөдөлмөр хоёр дахин өссөн, эсвэл хоёр дахин багассан гэе. Ингэвэл хоёр дахин өссөн нөхцөлд нэг бошинзны үнэт хоёр бошинзны үнэттэй адилхан болох ба харин нөгөө нөхцөлд хоёр бошинз нэг л бошинзны үнэттэй адилхан болно. Хэдийгээр бошинзыг үйлдвэрлэх нөхцөл өөрчилөгдөөгүй ч гэсэн, мөн түүнд зарцуулах хөдөлмөрийн чанар өөрчилөгдөөгүй ч гэсэн. Харин зөвхөн л үйлдвэрлэлд зарцуулсан хөдөлмөрийн квант өөрчилөгдсөн.

Хэрэгцээний үнэтийн томруулсан квант нэг үгээр хэлэхэд томруулсан эдийн хэмжээг хэлэх ба хоёр бошинзны эд нэг бошинзныхоос том л гэсэн үг. Хоёр бошинзоор хүн хоёр хүнийг хувцаслана, харин нэг бошинзоор нэг л хүнийг хувцаслана гэх мэт. Гэхдээ л эдийн массын өсөлт үнэтийн хэмжээний уналттай адил. Энэ хоёр эсрэг тэсрэг хөдөлгөөн хөдөлмөрийн хоёр янзын характеристаас гаралтай. Үйлдвэрлэх хүч гэдэг үргэлж натураасаа ашигтай болон конкрет хөдөлмөрийн үйлдвэрлэх хүч ба өгөгдсөн хугацаанд зорилготой продуктив ажилын АҮК -г тодорхойлдог. Ашигтай хөдөлмөр тиймээс баян эсвэл дутагдалтай үйлдвэрлэлийн эх булаг бөгөөд харин түүний үйлдвэрлэлийн хүчний уналт эсвэл өсөлттэй шууд харицаатай. Үүний эсрэгээр үйлдвэрлэх хүчний солигдол нэг үгээр хэлэхэд үнэт дотор дүрслэгдсэн хөдөлмөр юу ч биш. Яагаад гэвэл үйлдвэрлэх хүч хөдөлмөрийн бодит ба ашигтай формд хамаардаг тул мэдээж хөдөлмөрт хамаагүй ба ингэхдээ тэдгээрийн бодит болон ашигтай формоор абстракцлагдана. Үйлдвэрлэх хүч хэдийгээр солигдсон ч хамаагүй адилхан хөдөлмөр адилхан хугацааны дотор адилхан үнэтийн хэмжээтэй. Гэхдээ адилхан хугацааны дотор хэрэгцээний үнэтийн янз янзын квантыг нийлүүлдэг. Үйлдвэрлэх хүч өсвөл илүүг нийлүүлнэ, харин унавал багыг нийлүүлнэ. Үйлдвэрлэх хүчний солигдол хөдөлмөрийн өгөөжтэй өгөөж болон түүнд нийлүүлэгдсэн хэрэглэгээний үнэтийн массыг ихэсгэдэг. Харин ихэссэн нийт массын үнэтийн хэмжээг багасгадаг. Хэдийд вэ гэхээр тэр солигдол түүнийг үйлдвэрлэхэд зайлшгүй хөдөлмөрийн хугацааны нийлбэрийг богиносгосон гэвэл. Үүнийг бас урвуугаар дүрслэх боломжтой.

Бүхий л хөдөлмөр физиологийн утгаараа хүний хөдөлмөрийн хүчний гарц ба энэ чанараараа адилхан хүний болон абстракт хүний хөдөлмөрүүд барааны үнэтийг дүрсэлдэг. Бүх хөдөлмөр нөгөөтэйгүүр зорилготой гэдэг формоороо хүний

хөдөлмөрийн хүчний гарц. Бодит ашигтай хөдөлмөрийн чанараараа бүх хөдөлмөр хэрэгцээний үнэтийг үйлдвэрлэдэг.

Хэрэгцээний үнэт (*Gebrauchswert*): Тухайн зүйл чухал, ашигтай, мөн яг одоо хэрэглэж буйгаар үнэт.

Солилцооны үнэт (*Tauschwert*): Тухайн бараанд шингээсэн хүний хөдөлмөрөөр солилцоонд гаргаж тавих.

Үргэлжилэл бий...


Í. Áààñàíõ;

(n.baasanhuu@gmail.com)

Ò°ðèéí òèèîñîè

Томас Хоббэс

(Thomas Hobbes)



“Лэвиатан”

буюу

сүмийн ба иргэний төрийн бодис, форм ба хүчирхийлэл

Хэсэг 1: Хүний тухай

...Үргэлжилэл

Бүлэг 5: Ухамсар ба сайэнсын тухай

Бодол³⁸ гэдэг бол нэмэх үйлдэлээр нийт нийлбэр эсвэл нийлбэрийг ондоо нийлбэрээс хассаны үлдэгдэл гэдэгийг төсөөлөх төсөөлөл. Хэрвээ дээрх үгээр явагдах тохиолдолд, бүхий л хэсэгүүдийн нэрнээс бүтэний нэрийг гаргаж авах, эсвэл бүтэний нэр буюу нэг хэсэгийн нэр хоёроос ондоо хэсэгийн нэрийг гаргаж авах гэсэн төсөөлөл. Мөн хэдийгээр зарим кэйзүүдэд³⁹ тоонуудад шиг тооцоолох ондоо төрөлүүд⁴⁰ нэмэх ба хасахаар нэрлэгдвэл яг л үржих ба хуваах шиг нэг л үйлдэл яригдана, яагаад гэвэл үржих гэдэг бол тэнцүү юмсыг хамтруулж тоолох ба хуваах ни нэг юмнаас боломжийн хэрээр салгаж авах. Эдгээр тооцоолох төрөлүүд зөвхөн тоонуудад хамаатай бус, бас юмсад хамаатай ба юмсыг ч гэсэн хамтруулан

³⁸ Хүний бодол явагдах процесс;

³⁹ Хэсэгчилсэн ситуац;

⁴⁰ *engl.*: sort; *ger.*: Art;

тоолж эсвэл салгах боломжтой. Арифметикч⁴¹ хүн *тоонуудаар* нэмэх болон хасахыг сургадаг шиг геометрикчүүд *шугамаар* сургана, бэхлэх болон хиймэл *фигүүрүүд*, *өнцөгүүд*, *пропорцуудыг*,⁴² *хугацаануудыг* болон *хурдны*, *эрчимийн*, *хүчний* зэрэглэлүүдийг сургадаг. Логикчид үүнтэй адилаар *үгсийн дараалалаар* сургахдаа *баталгаа* гаргахын тулд хоёр *нэрийг* хамтруулдаг, *силлогизм* гаргахын тулд хоёр *баталгааг*, харин *нотолгоо* гаргахын тулд *олон силлогизмуудыг* хэрэглэдэг, цаашилбал *силлогизмоос нийлбэр* эсвэл *дүгнэлт* гаргаснаараа тэд *хэллэгийг* гаргаж авдаг, ингэснээрээ *ондоо хэллэгийг* гаргаж авах боломжийг олно. Харин *политикийн*⁴³ тухай бичдэг хүмүүс хүмүүсийн *үүрэгүүдийг* олохын тулд тааралдсан *гэрээнүүдийг* нэмэх ба шүүгч хүмүүсийн үйлдэлээ *зүйтэй* хийж үү, *зүйгүй* хийж гэдэгийг олохын тулд *хуули* ба *хэрэг* хоёрыг нэмдэг. Товчхондоо: Хаана *нэмэх* ба *хасах* явагдана, тэнд бас *ухамсар* байрлана, мөн тэдгээр хаана явагдахгүй вэ, тэнд *ухамсар* юуг ч хайх ёсгүй.

Одоог хүртэл хэлэгдсэн бүгдэд сууриалаад, хэрвээ бид *ухамсарыг* тэдний оюуны чадамжуудад тооцно гэвэл бид юуг *ухамсар* хэмээх үгээр илэрхийлж буйг дэфиницлэх, өөрөөр хэлбэл тодотгох боломжтой. Яагаад гэхлээр *ухамсар* энэ утгаараа *тооцоолохоос* огт ялгагдахгүй, энэ юу гэсэн үг вэ гэхлээр, ерөнхий нэрнүүдийг дарааллуулж нэмэх бас хасах бөгөөд тэр ерөнхий нэрнүүдээр бид бодолоо *тэмдэглэж зарлахдаа* хэдийнээ зөвшөөрчихсөн. Хэрвээ бид өөрсдөө тооцоолоод бас *зарлаад*, улмаар өөрсдийн тооцоолсноо бусадад нотлохыг эсвэл илтгэхийг хүсвэл би *тэмдэглэл* гэж хэлдэг.

Арифметикт дасгалжаагүйнууд андуурдагтай адил, профэссорууд хүртэл тогтмол эндүүрэх бөгөөд буруу тооцоолох боломжтой. Мөн үүнтэй ижилээр бодолын ондоогоор бодох зүйлүүдэд хамгийн чадамжтай, анхааралтай бас дасгалжсан хүмүүс ч эндүүрэх ба буруу дүгнэлтэнд хүрэх боломжтой. Ухамсар үргэлж зүйт ухамсар байдаггүй ба арифметик шиг баталгаатай бөгөөд балартсан биш урлаг⁴⁴: Гэхдээ баталгаа дан ганцын ухамсараас бус, хүмүүсийн ямарваа нэг тооноос ч бус олгогдоно - тиймээс тооцоо түүн шиг зөвөөр явсан гэсэн ойлголт биш, яагаад гэвэл тэр хүмүүсийн их хэмжээний тооноос таарсан зүйтэй хэмээн үзэгдсэн. Тиймээс талууд маргааны үеэр тооцоогоо зөвтгөх гэж шүүгчийн ухамсарыг зөв ухамсар гэдэгээр оруулдаг ба ингэж шүүгчийн шийдвэрт хоёулаа бэлэн шүү гэж илэрхийлдэг, эсвэл тэд гар хөлөөрөө шийднэ эсвэл шийдэл үгүй үлдэнэ, яагаад гэвэл натураас гаргасан зөв ухамсар гэж өгөгдөөгүй. Үүнийг бүхий л маргаануудад хэрэглэх боломжтой. Хэрвээ өөрсдийгөө бусадаас илүү гэсэн хүмүүс нэгэн дуунд хүрвэл шүүгчээс ямар ухамсарыг шаарддаг вэ гэвэл зөвхөн өөрсдийнхөө л

⁴¹ Математикийн нэг чиглэл болох тооцоолон бодох салбарын мэргэжилтэн хүн;

⁴² Нэг бүхэлийн хэсэгүүдийг хооронд ни харицуулсан харицаа;

⁴³ *Улс төр* гэж хоёр тусдаа бие даах ухагдахуунаар орчуулагдсаныг *политик* -оор орлуулан буулгав;

⁴⁴ *engl.*: art; *ger.*: Kunst;

ухамсарыг шийд гэсэн шаардлагад хүрдэг ба ингэж хүний нийгэмд тэвчишгүй болгодог. Жишээлбэл хөзөр тоглох үед хөзөрийн өнгө нэгэнт гарчихсаны дараа өөртөө олон хөзөрийн өнгийг гаргуулах гээд зүтгэж буйтай адил. Яг л ингэж зарим хүмүүс өөртөө буй ашигтайгаа цааш хадгалж бусдаар зөвшөөрүүлэх гэж бидний зөв ухамсарыг хэрэглэ гэж тулгадаг - ингэж тэд маргааныхаа үеэр зүй ни бидэнд бий гэж хэлсэнээрээ тэд хэн болохоо харуулдаг вэ гэхээр тэдэнд ухамсар дутагдаж буйгаа харуулдаг.

Ухамсарын ашиг ба зорилго юу вэ гэхээр нэг эсвэл олон дагаваруудын нийлбэр болон үнэнийг олохдоо биш, эхний дэфиницээс холуур, мөн баригдмал нэрнүүдийн утгууд биш, харин эндээс эхлэх ёстой бөгөөд дүгнэлтээс дүгнэлт рүү урагшлан ахих ёстой. Яагаад гэвэл хэдийд сүүлчийн дүгнэлт баттай вэ гэхээр бүхий л баталгаанууд болон үгүйсгэлүүд баттай болж тэдгээрт суурилсан бас тэдгээрээс гаргалгаатай дүгнэлтүүд баттай болсоны дараа сүүлчийн дүгнэлт гарна. Жишээлбэл гэр бүлийн аав гэрийнхээ худалдан авсан зүйлсийн нийлбэрийн тооцоог гаргах гэвэл нэг бүрчилсэн тооцоонуудыг харгалзаагүй ба юунд зориулан төлсөнийг ч харгалзаагүй гэвэл үүнийг зүгээр л ойролцоогоор тооцоолсон тооцоо гэх бөгөөд нэг бүрчилсэн хүмүүсийн хэрхэн үнэнчээр, бас овжиноор мөнгөө зарцуулсаныг итгээгүйтэй адил. Үүнтэй ижилээр хүн аливааг эргэцүүлэн бодохдоо дараах төрхийг гаргана: Хэн бусадын дүгнэлтийг зүгээр л хүлээж аваад тэдэнд итгэхдээ тооцоолсон тооцоонуудын датануудыг - жишээлбэл тохиролцсон нэрнүүдийн утгуудын дэфиницүүдээс - гаргалгаа гаргаагүй гэвэл тэр хүн ямар ч үр дүнгүй хичээлт гаргах ба юуны ч тухай мэдэлгүй зөвхөн үнэмших төдий.

Хэрвээ хүн нэг бүрчилсэн юмнуудад боломжтой үгсийг хэрэглэлгүйгээр тооцоолсон гэвэл, хэрвээ хүн юмсыг ажигласнаар магад өмнөхийг ни эсвэл тэндээс гарах гаргалгаанаас дүгнэсэн гэвэл ингэхдээ зөгнөсөн гаргалгаа дараагийн гаргалгаанаас гарч ирээгүй гэвэл, эсвэл бидний зөгнөсөн явц уридчилан явагдаагүй гэвэл бид *андууралын* тухай яридаг. Андууралд хамгийн билигтэй хүмүүс ч сөхөрдөг. Хэрвээ бид ерөнхий утгатай үгнүүдээр бодлоо гэвэл тэгснээрээ ерөнхий дүгнэлтэнд очлоо гэвэл, мөн энэ дүгнэлт буруу гэвэл энэ үнэхээр эсрэг утга гаргах ба эсвэл ямар ч утгагүй илэрхийлэл. Үүнийг энгийнээр андуурал гэж нэрлэдэг ч гэсэн, яагаад гэвэл андуурал өнгөрсөний болон ирээдүйг уридчилгаанд гаргасан зөвхөн эндүүрэл. Хэрвээ бид ерөнхий баталгаа гаргалаа гэвэл, хэрвээ тэр үнэн биш гэвэл, түүнийг боломжтой гэдэгээр төсөөлөхгүй. Үгсийн цуурайнуудыг бид зөвхөн сонсохдоо тэднийг *утгагүй, юу ч хэлэхгүй, мөн учир дутмаг* гэж нэрлэнэ. Ингэж хэрвээ надад хүн *тойроглосон дөрвөлжин бясланы доторх талхны хөгц* эсвэл *материаллаг бус субстанцтайгаар* ирлээ гэвэл, мөн цаашилбал *чөлөөт боолтой*, эсвэл саатуулсан эсэргүйцэлээс *чөлөөт*⁴⁵ биш ондоо *чөлөөт хүсэлээр*⁴⁶ ирлээ гэвэл,

⁴⁵ *engl.*: freedom; *ger.*: Freiheit;

⁴⁶ *engl.*: free will; *ger.*: freier Wille;

түүнийг би андууралд оржээ гэж хэлэхгүй ба харин түүний үгс утга агуулаагүй, нэг үгээр хэлэхэд эсрэг утгатай гэнэ.

Би дээр хоёрдугаар бүлэгт хэлсэнчлэн хүн бусад бүх амиадыг чадамжаараа давамгайлдаг, ямар чадамж вэ гэхээр дуртай юмсынхаа үр дагаваруудыг асуудаг түүнийгээ бас төсөөлдөг мөн юунд үйлчлэх вэ гэдэгийг төсөөлдөг. Ингээд би нөгөө л тунгаасныхаа ондоо шатлалд очих ба энэ бол чадвар, ямар чадвар вэ гэхээр түүнээс гарах дагаваруудыг ерөнхий дүрэм гэсэн үгнүүдийн тусламжтайгаар *тэорэм*⁴⁷ эсвэл *бодолын мөрүүд* гэж нэрлэснээр дүрэмүүдийг гаргадаг. Хүн зөвхөн тоогоор бодож эсвэл тооцоолдоггүй, түүнээс гадна бүхий л юмсыг нэгтгэж эсвэл хооронд ни салгадаг.

Энэ привилэг⁴⁸ ондоо привэлэг буюу нөгөө утга үгүйгийн привэлэгээр сулардаг, үүнд зөвхөн хүн гэгдэх амид биет өртдөг. Хамгийн их өртдөг хүмүүс бол философийн профэссорууд. *Цицэрогийн* хэлсэнээр философийн номнуудаас бусад газар зөвхөн л утгагүйнүүд. Үүний шалтгаан бидний гарт бий. Яагаад гэвэл тэд нэрийн дэфиницүүд болон тайлбаруудыг хэрэглэхдээ бодолынхоо эхлэл болгодоггүй. Энэ мэтодыг зөвхөн гэомэтрт хэрэглэдэг ба тэдний дүгнэлтүүд түүгээрээ маргаангүй болцгоосон.

1. Абсурд дүгнэлтүүдийн эхний шалтгаан минийхээр мэтодуудын дутагдалд буй. Тэд бодохдоо дэфиницүүдээс эхлэдэггүй ба нэг үгээр хэлэхэд тэд хатуу барисан үгсийн утгуудаас эхлэдэггүй - энэ юутай адилхан бэ гэхээр *нэг, хоёр* ба *гурав* гэсэн тоот үсэгүүдийн хэмжээг ни таниагүйгээр тооцоолохтой адил.

Яагаад гэвэл бүх биет ялгаатай ажиглалтуудаар тавигдаж, мөн ажиглалтууд ялгаатайгаар нэрлэгддэг тул тэднийг нэрлэсэн нэрнүүдийн будлиан болон тохироогүй холбоосууд ялгаатай утга үгүйдэлийн хэллэгүүдийг үүсгэнэ.

Тиймээс...

2. минийхээр буруу баталгаануудын хоёр дахи шалтгаан юу вэ гэхээр, *акцидэнцэд*⁴⁹ нэр өгөхдөө *акцидэнцтэй биетүүдийн* нэрийг өгсөн. Жишээлбэл түүний *үнэмшил цутгасан* эсвэл *үлээгдчихсэн* - гэвэл энд яг л биетийн тухай яриж буйтай адил ба биенээс гадуур юу ч *цутгагдаж* бас *үлээгдэж* чадахгүй - *бие тэлдэг*, харин *тусгалууд* ни *сүнс*.⁵⁰

⁴⁷ Сайэнсын тэоригоос гаргаж авсан сургаали;

⁴⁸ Оноогдсон тусгай эрх;

⁴⁹ Тохиолдолын;

⁵⁰ Энд хий үзэгдэлийн сүнс гэж орчуулав /орчуулагч/;

3. Гурав дахи шалтгааныг би хэрхэн харсан бэ гэхээр бид *өөрсдийнхөө биеийн акцидэнцүүдэд биднээс гадуурх биеийн акцидэнцүүдийн* нэрийг өгсөн. Жишээлбэл зарим хүмүүс хэлэхдээ *өнгө биенд, цуурай агаарт бий* гэнэ.

4. Дөрөв дэх шалтгааныг би харахдаа *нэрүүд ба илэрхийлэлүүдэд биетийн* нэрнүүдийг өгчээ. Жишээлбэл *ерөнхий юмсууд, амид биет гэдэг нэг төрөлтөн* эсвэл *нэг ерөнхий юм*.

5. Тав дахи шалтгааныг би харахдаа *нэрнүүд болон илэрхийлэлүүдэд акцидэнцүүдийн* нэрийг өгчээ. Жишээлбэл *юмны натур гэдэг түүний дэфиниц, хүмүүсийн тушаал гэдэг түүний хүсэл*.⁵¹

6. Зургаа дахи шалтгаан миний харсанаар метафэруудыг хэрэглэхэд болон үгсийн оронд зурагласан илэрхийлэлүүдийг хэрэглэжээ. Яагаад гэвэл, жишээлбэл өдөр тутамын яриандаа энэ *зам тийш явна эсвэл тийш хүргэнэ гэж зөвөөр яридаг ч, ямар ч зам өөрөө явахгүй бөгөөд зүйр үг тэгээж хэлжээ гэснээр ямар ч зүйр үг ярихгүй шүү дээ*, гэхдээ л үнэнийг тооцоолохдоо бас хайхдаа дээрх илэрхийлэлүүдийг зөвшөөрч болохгүй.

7. Долоо дахи шалтгааныг би нэрнүүдэд харсан ба тэд юуг ч илэрхийлэхгүй бөгөөд сургуулиудад заагдаж бас мэханикаар сургадаг. Жишээлбэл схоластикчидын хэлдэг *хипостатик, транс-субстанц, кон-субстанц, мөн үргэлж одоогийн* гэсэн үгс.

Хэн эдгээр юмсаас татгалзаж чадсан бэ, тэр хүн утгаа алдчихсан зүйл дотор хялбар орохгүй, хэт тооцооны уртаасаа уридчилсаныгаа тэр хүн мартачихаж болохгүй. Бүх хүмүүс өөрсдөө сайн горимуудтай бол натуураасаа адилхан бас сайн хэмээн бодно. Хэн гэомэтрт гаргасан дутагдалаа ондоо нэг ни зааж өгсөөр байтал ахиад зөрүүдлээд байхаар тийм тэнэг билээ?

Үүнээс бид юуг олж харах вэ гэхээр, ухамсар бидэнд мэдрэхүй эсвэл санамж шиг төрөлхийн биш, эсвэл билигтэй адил цэвэр туршлагаар өөртөө авах боломжгүй. Тэрээр илүү чармайлтаар олгогддог: Эхлээд нэрнүүдтэйгээ тааруулж өгөхөөр, хоёрдугаарт элэмэнтүүдийн ахицын сайтар бөгөөд системчлэгдсэн мэтодын эзэмшсэнээр, нэг нэр ондоо нэртэйгээ холбогдогоор үүсэх баталгаануудад нэрийг, мөн ялгаагүй силлогизмд ч, нэг баталгаа нөгөөхтэй холбогдох тэр холбоосуудад бид асуугдаж буй зүйлд хамаарах нэрнээс дагаварлах бүгдийг танитал бид чармайх хэрэгтэй. Үүнийг л бид *сайэнс* гэж нэрлэдэг. Мэдрэхүй болон санамж зөвхөн хэрэгийн танихуй болох мөчид, өөрөөр хэлбэл өнгөрсөнөөс, мөн буцаагдашгүйгээс *сайэнс* гэдэг бол нэг хэрэгээс нөгөө рүү дагаварлах бас нэг ни нөгөөгөөсөө яаж хамааралтай буйн танихуй. Тэдгээрээр, хэрвээ бид хүсвэл өөрсдийгөө одоо үед юу

⁵¹ *engl.:* will; *ger.:* Wille;

хийж чадах, яаж ондоо ни эсвэл нөгөө ни ондоо нэг цаг мөчид баригдахыг бид танидаг. Яагаад гэвэл бид ямар шалтгаанаар бас ямар шинжээр төлөвшихийг хардаг, түүнчлэн бид адил шалтгааныг яаж шалтгаанжуулах боломжтойг болон хэрвээ тэдгээрт бидний хүч нөлөөлвөл тэнцүү үйлчлэлийг авчирахыг бид хардаг.

Тиймээс хүүхэдүүд яриж сурталаа ухамсарыг ерөөс эзэмшидэггүй, тэгсэн ч гэлээ ирээдүйд ухамсарыг эзэмших нээлттэй боломж буйгаас тэднийг ухамсартай төрөлтөн гэж нэрлэдэг. Хэдийгээр ихэнх хүмүүс бага зэрэг бодож чадавч, жишээлбэл тодорхой хэмжээгээр тоолоход тэдний өдөр тутамын амидралд төдийлөн ашиглагддаггүй. Үүнд тэдгээрийн ялгаатай үзсэнүүд, санамжийн хурд болон татагдалаар ялгаатай зорилгуудад, нэгийг ни давуу, нөгөөг ни дорой, ялангуяа тэдгээрийн аз эсвэл аз үгүйдэлээр болон бие биенээсээ өвлөх андууралаар чиглэгддэг. Яагаад гэхлээр *сайэнсаас* эсвэл тэдгээрийн үйлдэхийн тухай баталгаатай дүрэмүүдээс тэдгээр ни юу гэдэгийг мэдэхээргүй болтолоо хол алслагддаг.⁵² Тэд гэомэтрийг шуламын гэсэн, бусад сайэнсуудад зарим анхна шалтгааныг танилцуулаагүй, гэхдээ бага ч гэсэн дэвшил гаргасан хүмүүс яг л хүүхэдүүд хэрхэн олдсон ба бүтээгдсэн талаах ямар ч баримжаагүй ба тэдэнд эмэгтэйчүүд юу гэж мэдлэсэн бэ гэхээр ах эгчүүд чини төрөөгүй, харин тэднийг хашаан доторх цэцэрлэгт олсон гэж хэлсэн.

Хэн *сайэнсыг* эзэмшээгүй тэр өөрийн натурын билигээрээ бусад хүмүүсээс илүү давуу ба нэр хүндтэй, яагаад гэвэл энэ хүмүүс буруу боддог, эсвэл буруу бодож мөн абсурд дүрэмүүдэд очсон хүмүүст итгэдэг. Яагаад гэвэл шалтгааны болон дүрэмийн үл танихуй хүмүүсийг буруу дүрэмтэй тулгарах болон юмсыг илүүтэй эсрэгийн шалтгаан гэж үзэх шиг замаас ни тийм алс дагуулахгүй.

Дуусгахын тулд: Тунгалаг үгс бол хүний оюуны гэрэл, гэхдээ зөвхөн эксакт дэфиницүүдээр угаагдаад хоёр утга илэрхийлэхээс цэвэрлэгдсэн бол. *Ухамсар* бол *алхам*, *сайэнсыг* олшруулах бол *зам* тэгвэл хүн төрөлхтөний тансаглал бол *зорилго*. Үүний эсрэг мэтафэрууд харин учир дутмаг бас *андуурал* шиг хоёр утгат үгнүүд ба тэдгээр ни бодолын өмнө мөхнө гэдэг тоймгүй олон утгагүйнүүдээр хэсүүчилдэг, түүний эцэст маргаан ба сандрал эсвэл дуулгавар үгүй байдаг.

Баялаг үзсэнүүд *билиг* гэдэгтэй адил сайэнсаар баян гэвэл *цэцэн*. Бид хэдий цэцэн гэх нэрийг хоёуланд ни хэрэглэх тул ромчууд үргэлж *прудэни*⁵³ ба *сапиэни*⁵⁴ гэж ялгагддаг, гэхдээ тэд туршлагад бичсэн эхнийх, сайэнсд бичсэн сүүлийнх. Тэгвэл ялгааг илүү тодотгохын тулд бид гайхамшигтай натурлаг төхөөрөмжийг өөрийн зэвсэгийн овжин хэрэглээнд эзэмших нэг хүнийг төсөөлцгөөе, дэргэд ни харин энэ

⁵² Тэдэнд сайэнс ба баттай суури зарчим харийн, яагаад гэвэл тэд шуналаас ондоо амидралын дүрэмийг танихгүй;

⁵³ Амидралд илүү юм үзэж туршлага хуримтлуулсан;

⁵⁴ Сайэнсын илүү мэдлэгтэй;

овжиний хажуугаар бас сайэнсыг илүү эзэмшсэн ондоо нэгийг, ингээд ямар маягаар бүх барилд эсвэл тавилд онох эсвэл өөрийн сөргөлдөгчид оногдох боломжтойг ни. Эхний хүний чадамж цэцэн дэх билиг шиг хоёр дахийн чадамжид төрх гаргасан; хоёулаа ашигтай ч гэсэн цэцэн хүн хэзээ ч дутах ёсгүй. Гэхдээ хэн номнуудын ауторитид итгэнэ бас сохоруудыг сохор мэт дагана тэрээр өөрийн итгэлээр сэлэмийн мастэрын буруу дүрэмээр биеэ тоож дайсан руугаа ойртоно, харин дайсан түүнийг нэг бол ална, эсвэл хэн ч биш болгоно.

Сайэнсын тэмдэгтүүд нэг талаасаа баталгаатай бөгөөд дутагдашгүй, нөгөө талаасаа батаалгаагүй. Хэрвээ сайэнсыг хэн нэгэн зүйлээс олж авсан бол тэр сургадаг гэдэгт тэд баттай, өөрөөр хэлбэл тэдгээрийн үнэн ондоо нэгт тунгалаг бөгөөд тод дэмонстрацлаж чадна. Хэрвээ зарим дан ганц дүнгүүд түүний баталгаатай дүйцээд олон кэйд өгөгдөлийн дагуу төлөвших ёстойгоор төлөвшвөл тэд баталгаагүй. Билигийн тэмдэгтүүд бүгт баталгаагүй, яагаад гэхлээр туршлагаар ажиглах болон ондоо гарцад нөлөөлөх бололцоотой бүх нөхцөлүүдийг санах гэдэг боломжгүй. Гэхдээ энэ дутагдашгүй сайэнсаар түрүүлэх бус үл тоомсорлосон үсэгэн сургаали гэж ерөнхий нэрлэгдэх танхайралын нэг тэмдэгт, хэрвээ өөрийн натурын ялгавар шантравал, улмаар номноос уншсан болон олон онцгойлолуудад хамрагдах ерөнхий өгүүлбэрүүдээр зааварчилагдвал бүх үйлдэлүүдэд бий. Төрийн зөвлөлийн коллэжуудад хүртэл өөрийн политикийн болон түүхийн тухай уншсанаа дуртайяа үзүүлэнд тавих эрчүүдийн дунд хувийнхаа явдалд тааруулаад хангалттай билиг эзэмшчихсэн хэдий ч онцгой сонирхолын тухай яригдахад үүнийг гэрийнхээ явдалд оруулж хийх хүн цөөхөн. Нийтэд тэр хүмүүст зөвхөн сайнаар тусах эсвэл бусадын хийсэн амжилтууд чухал биш, харин тэрнээс илүү зүйлс хамаатай.

Үргэлжилэл бий...

А. Аайтөө

(gankhulug@yahoo.com)

Бидний арван жаргалын ёс эрүүл мэнд

Дээр тогтдог.

Шопэнхауэр.



үргэлжийн бүтэн структур. Тиймээс энд түүнд конституцласан моментууд янз бүрийн харцыг олгоно. Энэ стурктурын өгөгдсөн бүтэнийг үргэлж хараандаа тогтоох дотор тэр моментуудыг фэномэналаар цоройх ёстой. Ингэж анализын зүйл болдог: Ертөнцийг түүний өөрийн ертөнцлөг дотор \Капитал 3\, Ертөнц-Дээр-Байх-ыг хамт ба өөрөө Байх \Капитал 4\, Дотоор-Байх-ыг тийм л гэх \Капитал 5\, Фундаментал стурктурын анализын хөрсөн дээр Дазайн-ы Байх-ын түр харуулах боломжтой. Түүний эксистэнциал учир гэвэл хөөцөлдөх \Капитал 6\.

I. Дазайн-ы бэлтгэсэн анализын даалгаварын экспозиц

9. Дазайн-ы аналитикийн сэдэв

Энд даалгавар гэж буй анализдах ёстой Байгаанууд⁵⁵ бид өөрсдөө. Энэ Байгаанууд-ын Байгаа минийх Байх. Байгаанууд-ын Байх дотор энэ өөрөө өөрийнхөө Байх руу төрх гаргана. Энэ Байх-ын Байгаа гэдэгээр өөрийнхөө хувийн Байх-д хариулдаг. Байх ерөөсөө л энэ Байгаа-д яасан тухай. Дазайн-ы энэ характэристикаас дараах хоёр асуулт гарна:

1. Энэ Байгаанууд-ын эссэнц өөрийн Байх дотор. Энэ Байгаа-гийн Юу Байх \эссэнциа\ түүний тухай ярилаа гэхэд өөрийнхөө Байх-аас \эксистэнциа\ гэж ойлгогдох ёстой. Үүгээр онтологийн даалгаварыг харуулдаг ба хэрвээ бид энэ Байгаанууд-ын Байх-д эксистэнц гэсэн тэмдэглэгээг сонговол мөн энэ гарчиг эксистэнциа -гийн уламжлагдсан тэрминий онтологийн утгыг эзэмшихгүй мөн эзэмшиж чадахгүй. Эксистэнциа онтологоор уламжлагдсанаараа ойролцоогоор Гарт Байх гэсэн ухагдахуун. Энэ Байх-ын төрөл бөгөөд Байгаанууд-ад Дазайн-ы характэраараа эссэнциалаар өгөгдөөгүй. Энд гарах будлиан юугаар зайлуулагдах вэ гэхээр бид эксистэнциа гэсэн гарчигийг үргэлж интэрпрэтацлагдсан илэрхийлэл Гарт гэсэнээр хэрэглэнэ. Харин эксистэнцэд Байх-ын тодорхойлол гэдэгээр Дазайн-ыг оноолоо.

Дазайн-ы эссэнц түүний эксистэнц дотор. Энэ Байгаанууд-д гаргасан характэрууд ингэж л харагдуулсан Гарт Байгаанууд-ын чанарууд биш харин түүнд боломжоороо Байх ба зөвхөн тэр. Энэ Байгаа-гийн бүх Ийм Байх примэр Байх. Тиймээс Дазайн гэсэн гарчиг нэг үгээр хэлэхэд бидний Байгаа-г нэрлэдэг гарчиг өөрийнхөө юу гэдэгийг илэрхийлэхгүй. жишээлбэл ширээ, байшин, мод биш харин зөвхөн Байх.

2. Байх энэ Байгаа-д түүний Байх-ын тухай л тул энэ ерөөсөө минийх. Дазайн-ыг онтологоор хэрэг мөн жишээ гэж Байгаанууд-ын төрөл мэтээр Гарт гэж яригдахгүй.

⁵⁵ Хэйдэггэр Ертөнц дээр байгаа бүх юмсыг “Seinde” буюу “Байгаанууд” гэсэн ухагдахуунаар илэрхийлсэн.

Энэ Байгаа-д түүний Байх адил хүчинтэй, яг харахад “ийм Байх” ба түүний Байх адил хүчинтэй эсвэл адил хүчингүй ч боломжтой. Дазайн руу ярихад Байгаанууд-ын ерөөсөө минийх гэсэн характераараа пэрсонал проноун⁵⁶ хамтаруулан хэлдэг: “би байна”, “чи байна”.

Дазайн минийх гэдэгээрээ иймээр эсвэл тиймээр Байх. Ерөөсөө үргэлж Дазайн хэрхэн минийх гэдэгээрээ үргэлж уриднаас шийдэгдчихдэг. Байгаа түүний Байх-д түүний өөрийн тухай тул тэр өөрийнхөө Байх-д хувийнхаа боломжит мэтээр төрх гаргана. Дазайн тэгэхээр түүний боломж ба тиймээс Дазайн түүнийг зөвхөн чанараар Гарт бий биш. Яагаад гэвэл Дазайн түүний боломж тул энэ Байгаа түүнийхээ Байх дотор өөрийгөө сонгоно. Гэхдээ өөрийгөө алдах боломжтой нэг үгээр хэлэхэд хэзээ ч биш бас зөвхөн туяарах боломжтой. Алдана гэдэг зөвхөн боломжтой, өөрийгөө олоогүй гэдэг хэдийд зөвхөн боломжтой вэ гэхээр тэр өөрийнхөө эссэнцээр боломжоороо ерөөсөө хувийн гэвэл. Байх-ын хоёр моди “*ерөөсөө*” ба “*ерөөсөө биш*” хоёр илэрхийлэл яг үгийн утгаараа тэрминологичилон сонгогдсон ба юунд суурилсан бэ гэхээр Дазайн өөрийнхөө минийх гэдэгээр характерчилагдсан. Дазайн-ы *ерөөсөө биш* -ийн утга багаар Байх эсвэл доогуур Байх-ын зэрэглэл биш. *Ерөөсөө биш* илүүтэй Дазайн-ыг бүрэн конкретоор характерлахдаа түүний ажилсаг дотор, цочоолт дотор, сонирхол дотор мөн эдлэх чадвар дотор.

Дазайн-ы скицлэсэн хоёр характерууд. Эссентиагийн өмнүүр эксистэнтиаг уридуурчилах мөн дараагаар минийчилэх юуг харуулдаг вэ гэхээр энэ Байгаа-гийн аналитик онцгой төрөлийн фундаментал газарт тавигдсан. Энэ Байгаа Ертөнц доторх зөвхөн Гарт буй⁵⁷ -гийн Байх төрөл биш ба хэзээ ч биш. Тиймээс *Гарт буй* -г өмнөө олохыг сэдэвчилж уридчилан өгөхгүй. Түүнийг зөвөөр өгөх гэдэг мэдээжийн биш ба түүний тодорхойлол өөрөө Байгаа-гийн онтологичилсон аналитикийн гол хэсэгийг гаргадаг. Байгаанууд-ын зөвөөр өгөгдөх баталгаатай гүйцэлдүүлэх ямар боломжийг өгдөг вэ гэхээр энэ Байгаанууд-ын Байх ойлгоцод хүргэгдэнэ. Энэ анализ түр гэгдэх боломжтой ч тэр үргэлж хэдийнээс зөв бичлэгийн баталгааг шаарддаг.

Дазайн өөрийгөө Байгаанууд-ын нэг гэдэгээр тодорхойлохдоо ямар боломжоос тодорхойлдог вэ гэхээр өөрийн Байх-ыг яаж ийгээд ойлгох. Энэ Дазайн-ы эксистэнцийн тогтнолын формалчилагдсан учир. Түүнд онтологичилсон интэрпретацид зориулсан удирдамж тавигдсан ба Байх-ын проблэматикийг

⁵⁶ Пэрсонал проноун - personal pronoun - англи, герман хэлний грамматик ба субэкт болон юмсыг төлөөлүүлэн хэрэглэдэг үгсийг \he she it, his, her, it's...\} монгол хэлэнд “би, чи, тэр” гэдэгээр хэрэглэдэгээс биш “he she” гэх мэт үгс, түүнийг хэрэглэх грамматик үгүй;

⁵⁷ Гарт буй Дазайн -ыг илэрхийлсэн ухагдахуунуудын нэг;

эксистэнцийн эксистэнциалитигээс хөгжүүлдэг. Гэхдээ энэ юуг хэлээгүй вэ гэхээр Дазайн эксистэнцийн конкрет боломжтой идэйнээс конструкцлагдана гэдэгийг. Дазайн анализийн тодорхой эксистэлсэн дэфэрэнц дотор интэрпретацлагдаагүй. Харин түүний дэфэрэнц биш эхлээд мөн ихэнхдээ дотор сөхөгдсөн. Дазайн-ын өдөр тутамын энэ *дэфэрэнц биш Юу ч биш* биш, *дэфэрэнц Юу ч биш*. Харин энэ Байгаагийн позитивчилсон фénomэнэлчилсан характэр. Түүний Байх төрөлөөс гаралтайгаар мөн түүн рүү буцаад бүгд яаж ч гэсэн эксистлэх. Бид Дазайн-ы өдөр тутамын *дэфэрэнцийг биш* дундаж гэж нэрлэдэг.

Яагаад гэвэл дундаж өдөр тутам энэ Байгаа-гийн онтчилсон *эхнээсээ* -г гаргадаг тул тэр Дазайн-ы экспликацид үргэлжийн алгасдаг. Онтчилсон хажуугийнууд болон танилууд онтологичиллоороо харийн, таниагүйнүүд мөн онтологичилолын утгаараа үргэлж анзаараагүйнүүд. Хэрвээ Августин дараахыг асуувал дараахыг хариулдаг: Энэ онтчилсон болон өмнөх онтологичилсон Дазайн-ы нэвт харагдахгүйгаас хүчинтэй биш харин онтологичилсон даалгаврын өндөржүүлсэн хэмжээнд хүчинтэй бөгөөд энэ Байгаа өөрийнхөө фénomэнэл дараагийн Байх төрөлөөрөө зөвхөн алдахгүй гэдэгтээ биш бас позитив характеристик дотороо орох боломж гаргах.

Дазайн-ы дундажласан өдөр тутам энгийн аспект мэтээр яригдаж болохгүй. Түүн дотор мөн *ерөөсөө бишийн* модус дотор ч гэсэн априороор эксистэнциалитигийн структур зогсдог. Бас түүн дотор ч гэсэн Дазайн-д тодорхой шинжээр түүний Байх-ыг хамааруулдаг. Түүнд харин дундажласан өдөр тутамын модус дотор харицах ба хэдийгээр түүний өмнөх зугталтын болон түүний марталтын модуст ч гэсэн.

